



**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР  
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ  
АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ  
НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ**

2025 оны 03-р сарын 10-ны өдөр

№ 02

Бүрэгхангай сум

Энэхүү гэрээг нэг талаас Булган аймгийн Бүрэгхангай сумын Засаг дарга **Эрдэнэбат** овогтой **Эрдэнэбулган** /цаашид "нутгийн захиргааны байгууллага" гэх/, нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч **ПЛАТИНУМЛАНД ХХК**-ийн захирал **Төмөрхүрээ** овогтой **Төрмөнх** /цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхайн нөхөрлөл" гэх/ нар /цаашид хамтад нь "Талууд" гэх/ Монгол улсын "Ашигт малтмалын тухай" хуулийн 42,43,44-р зүйл, ЗЗНДНТУ-ын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль болон бусад хуулиудийн зүйл заалтуудыг үндэслэл болгон дор дурьдсан нөхцөлүүдийг хэлэлцэн харилцан тохиролцож Булган аймгийн Бүрэгхангай суманд энэхүү нийгмийн хариуцлагын гэрээг байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Талууд энэхүү гэрээгээр орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уурхайн ашиглалт, үйлдвэрлэлтэй холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг харилцан уялдаатай хөгжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор гэрээний хугацаанд хамтран хэрэгжүүлэх ажлын төрөл, хугацааны талаар харилцан зөвшилцөж хийгдэх ажлын жагсаалтыг баталж хэрэгжүүлнэ.

1.2. Энэхүү гэрээгээр орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, бичил уурхайн нөхөрлөлүүд нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагааг тогтвортой хэвийн явуулах, сум, орон нутгийн хөгжилд бодитой дэмжлэг үзүүлэх талаар хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.3. Энэхүү гэрээг **MV- 000181** дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй эзэмшигчтэй байгуулна.

1.4. Орон нутагт хийх бүтээн байгуулалтын ажлын өртөг болон мөнгөн хандив тусламжийн хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3-т заасан хэмжээгээр тодорхойлогдоно.

**Хоёр. Хамтын ажиллагааны зарчим**

2.1. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах.

2.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх, хариуцлагатай ажиллах.



2.3. Талууд нь хуулиар хүлээсэн үүргийг харилцан хүндэтгэж, хуулийг дээдлэх

### **Гурав. Талуудын эрх, үүрэг**

#### **3.1. Нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг**

3.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах,

3.1.2. Энэхүү гэрээний хүрээнд хэрэгжүүлэх ажлыг дэмжих, хамтарч ажиллах, орон нутгаас хамааралтай бэлтгэл ажлыг хангах, улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, хөтөлбөрүүдтэй давхцуулахгүй байх талаар хяналт тавих,

3.1.3. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд мэдээлэл өгч, саналыг нь авах. Гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, сумын Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнах.

3.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах,

3.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих,

3.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх,

3.1.7. Гэрээнд заагаагүй ажил, санхүүжилтийг болон хуульд заагаагүй татвар, төлбөр хураамжийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардахгүй байх,

3.1.8. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардах,

#### **3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

3.2.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэд, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт тавьж шийдвэрлүүлэх.

3.2.2. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах
- .... га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн байх,
- ..... га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн байх,
- Усны бохирдол хомсдлоос сэргийлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, ус ашиглалтыг тоолууржуулах

3.2.3. Орон нутгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах чиглэлээр:

- Уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх,
- /Нутгийн захиргааны байгууллагаас санал болгосон төсөл, арга хэмжээнээс сонгож, энэ хэсэгт оруулах/

3.2.4. Ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр:

- Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч



ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах

- Нийт ажлын байрны 40 доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшиний сургатад хамруулсны үндсэн дээр ажиллуулах

3.2.5. Уурхайн хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг Бүрэгхангай сумын аж ахуйн нэгж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээр хангах чиглэлээр:

- Мах, сүүний хэрэгцээг 100% хангана. /.... бод, .... бог, ..... литр сүү авна./
- Хүнсний ногооны хэрэгцээг хангана. / .... тн төмс, ... тн хүнсний ногоо/
- Өргөн хэрэглээний хүнсний бараа бүтээгдэхүүнийг сумын худалдааны аж ахуйн нэгжүүдээс худалдан авах

3.2.6. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах,

3.2.7. Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх,

3.2.8. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, нутгийн иргэдэд хагас, бүтэн жилээр мэдээлэл өгч ажиллах,

#### **Дөрөв. Гэрээний хэрэгжилт**

4.1. Талууд гэрээг тухай жилийн 1 дүгээр улиралд багтаан байгуулж, гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг, сумын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөлд хүргүүлнэ.

4.2. Талууд гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, аймаг, сумын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөлөөр баталгаажуулан, хагас жилийн хэрэгжилтийг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн хэрэгжилтийг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

4.3. Орон нутагтай байгуулсан Нийгмийн хариуцлагын гэрээний хагас, бүтэн жилийн хэрэгжилтийг хавсралтад заасны дагуу сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны алба, Санхүүгийн алба 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор дүгнэж, сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралд танилцуулна.

#### **Тав. Гэрээний зарцуулалт**

5.1. Монгол Улсын Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх.

5.2. Төрийн албан хаагчдын сургалт, сурталчилгаа, нийгмийн асуудлыг шийдвэрлэх

5.3. Олон нийтийн арга хэмжээ, чуулга уулзалт, Урлаг, спортын тэмцээн, уралдааны зардал

5.4. Сум орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр (Гэржүүлэх, сургалтын төлбөр)



5.5. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилтын дутуу хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх

5.6. Эмчилгээний төлбөр

5.7. Баг, байгууллага, төрийн албан хаагчдын техник, тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэх

#### **Зургаа. Гэрээний хариуцлага**

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

#### **Долоо. Бусад**

7.1. Гэрээ байгуулагч аж ахуйн нэгжийн хандив, дэмжлэг туслалцаатайгаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн салбаруудын хөгжлийг тодорхойлсон бодлогын баримт бичигт тусгагдаж тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр баталгаажна.

7.2. Санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсанаас хандив, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт бусад холбогдох мэдээллийг гэрээ байгуулах аж ахуйн нэгжүүдэд урьдчилан хүргүүлж танилцуулан, хэрэгжүүлэх эсэхийг аж ахуйн нэгжийн саналаар сонгуулан зөвшилцөн тохиролцсон байна.

#### **Найм. Маргаан шийдвэрлэх**

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

#### **Ес. Гэрээ хүчин төгөлдөр болох**

8.1. Талуудын гарын үсэг зурсан өдрөөс хойш */тухайн жилдээ/* гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.3. Гэрээг 2 хувь үйлдэж, хувийг нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тус тус хадгална.

---oooOOOooo---

5.6. Үүсгэж байгаа хүүхдийн хөгжлийн үндэсний үзүүлэлтүүдийг үндэсний үзүүлэлтүүдийн хүрээнд үнэлж, үнэлгээний үр дүнд хэрэглэнэ.

5.7. Үүсгэж байгаа хүүхдийн хөгжлийн үндэсний үзүүлэлтүүдийг үнэлж, үнэлгээний үр дүнд хэрэглэнэ.

### Дүгнэлт

5.8. Үүсгэж байгаа хүүхдийн хөгжлийн үндэсний үзүүлэлтүүдийг үнэлж, үнэлгээний үр дүнд хэрэглэнэ.

5.9. Үүсгэж байгаа хүүхдийн хөгжлийн үндэсний үзүүлэлтүүдийг үнэлж, үнэлгээний үр дүнд хэрэглэнэ.

### Хяналтын үндэсний үзүүлэлт

5.10. Үүсгэж байгаа хүүхдийн хөгжлийн үндэсний үзүүлэлтүүдийг үнэлж, үнэлгээний үр дүнд хэрэглэнэ.

### Хяналтын үндэсний үзүүлэлт

5.11. Үүсгэж байгаа хүүхдийн хөгжлийн үндэсний үзүүлэлтүүдийг үнэлж, үнэлгээний үр дүнд хэрэглэнэ.

5.12. Үүсгэж байгаа хүүхдийн хөгжлийн үндэсний үзүүлэлтүүдийг үнэлж, үнэлгээний үр дүнд хэрэглэнэ.

5.13. Үүсгэж байгаа хүүхдийн хөгжлийн үндэсний үзүүлэлтүүдийг үнэлж, үнэлгээний үр дүнд хэрэглэнэ.

“ПЛАТИНУМЛАНД” ХХК-тай  
2025 оны 03-р сарын 10-ны өдөр  
байгуулсан гэрээний хавсралт

2025 ОНД ХИЙХ БҮТЭЭЛЧ АЖЛЫН ЖАГСААЛТ

д/д	Заалт	Төсөвт өртөг (сая.төг)	Хариуцах эзэн
1	Гэрээний 5 дугаар зүйл заалтын дагуу зарцуулна	80,0	Э.Гэрэлт-Эрдэнэ
2	Төлбөр төлөх хугацаа	2025.04.25-нд 32,0 сая төгрөг 2025.05.26-нд 24,0 сая төгрөг 2025.06.25-нд 25,0 сая төгрөг	

Нийгмийн хариуцлагын гэрээний данс: Бу. Бүрэгхангай ОНХСан 100040352400

